

**Монгол аман зохиол дахь барын
дүр, бэлгэдэл**

Ганболдын БАТМӨНХ *

*Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Аман зохиол судлалын салбар*

Received: Jun 12, 2024

Revised: Jul 13, 2024

Accepted: Aug, 15, 2024

Хураангуй: Өгүүлэлд ертөнцийн дөрвөн хүчтэний нэг болох барыг монгол аман зохиол, утга соёлд хэрхэн дүрсэлж ирснийг жишээгээр тодруулж, өнөөдөр бидний үед тэрхүү уламжлал хэрхэн хадгалагдаж буйг өгүүлэв. Чингэхдээ тууль, домог, үлгэр, оньсого, зүйр цэцэн үг зэрэг аман зохиолын төрөл зүйлсэд барын дүрийг хэрхэн дүрсэлснийг тодруулж, монголчуудын уламжлалт ан ав, зүүд, зүгийн бэлгэдэл, газар шинжих ёс зэрэгтэй харьцуулан тэдгээрийн утга бэлгэдлийг тайлан тайлбарласан байна.

Түлхүүр үг: аман зохиол, дөрвөн хүчтэн, дүрийн судалгаа, сүр хүч

**Symbolism and description of tiger in
Mongolian folklore**

BATMUNKH Ganbold

*Department of the Folklore studies, Institute of Language and
Literature, Mongolian Academy of Sciences, Mongolia*

Abstract: This article tells about description and status of tiger which are assumed as ones of the four leviathans in Mongolian folklore and literary culture. For this the article not only dealt with epics, myths, tales, riddles, and proverbs but also Mongolian traditional land examining custom. There are full of roles and symbols of tiger in Mongolian literary culture, customs, and folklore.

Tiger is deeply absorbed in literary culture than other animals that feeds Mongolians and have a significant impact on his lives. That is why it is interesting although tiger do not live in Mongolia. To clarify the reason of how they become part of Mon-

* © Г.Батмөнх
Email: batmunkhg@mas.ac.mn

golian literary culture we should consider the issue in connection to the symbolism of “four leviathans”.

There is a vital notion in oriental culture is the conjunction of symbols and description of the “four leviathans”. Originated place and date of this notion is not fixed but there are many hypothesizes and proposals. The most popular explanation is the following: Initially the myth roles named asuri, tengri, dragon are formed in mentality of Orientals after that the concept was born which expressed upper world, middle world, and lower world. There are two leviathans each in upper world and also middle world separately. Then altogether they called “four leviathans”. The myths were originated from India and China.

The two leviathans in upperworld among the “four leviathans” are named dragon and garuda. The lion and tiger are leviathans of middle world which do not live in our country. Considering the roles of the tiger in Mongolian folklore, the epic named “Erkhiidee erchtei Eriin sain Khambuudai mergen khan” it is said as following:

*“Manglai čayan arslan
Mal-i ni toyurin (toylajū)
Qatun bars-un juljay-a
Qatun-I toyurin (toylajū) jeg d lebe gen-e”. It means ruling the tiger is
a symbol of the ability to repress evil.*

Further in a Mongolian epic the lion is described:

*“Bayan-a tal-a-du ni bars arslan
Bajayalaulun seyilügsen
Dalan tabun teremetei bayiday
Dalan yurban unitai bayiday”
“Aduučin sayin aγ saqal ebügen
Aba-a aq-a ni aru-du ergiged
Arban jil-dü ködülgedüi
Arslan čayan
Abdar-a-yin čooji-yi multuluad”
Clarified the behaviours of its great power and rapid physique.*

Key words: *folklore, four leviathans, tiger, Symbolism, Mongolian traditional*

1. Удиртгал

Монгол утга соёл, аман зохиол, зан заншилд барын дүр, дүрслэл, түүгээр бэлгэдсэн зүйлс түгээмэл бий. Өдгөө монгол оронд оршин амьдардаггүй атал монгол нутагт амьдардаг, монголчуудын ахуй амьдралд чухал нөлөөтэй зарим амьтдаас ч илүүтэй уламжлалт утга соёлд гүн шингэсэн байдаг нь сонирхолтой. Үүний учир нь “дөрвөн хүчтэн”-ий утга бэлгэдэлтэй салшгүй холбоотой. “Ертөнцийн дөрвөн хүчтэн”-ий тэнгэрийн хоёр хүчтэн болох луу, хангарди хоёр домгийн амьтан байх бөгөөд газрын хүчтэнүүд болох арслан, бар хоёр өмнө өгүүлсэнчлэн манай оронд оршин амьдардаггүй амьтад байна. Ийнхүү тэнгэрийн хоёр хүчтэн нь домгийн амьтад, газрын хоёр хүчтэн нь манай оронд

өдгөө оршин амьдардаггүй хэдий ч монголчуудын утга соёл, аман билигт дөрвөн хүчтэний бэлгэдэл, уламжлал үлэмж их тул үүнийг тодруулан судлах нь чухал байна.

Дорно дахины утга соёл дахь нэгэн гол ойлголт бол “дөрвөн хүчтэн” хэмээх бэлгэдэл, дүр дүрслэлийн цогцолбор билээ. Чухам хэдий үеэс, аль орон улсаас үүсэн бий болсон нь тодорхойгүй ч таамаг, саналууд олон бий. Эртний “дорно дахины орнуудын хүмүүсийн сэтгэлгээнд асури, тэнгэр, луу гэх мэтийн үлгэр домгийн амьтад үүсээд дээд, дунд, доод гурван тивийн ойлголт гарч ирсэнтэй холбогдон дээд тив буюу тэнгэрийн хоёр, дунд тив буюу газрын хоёр бүгд дөрвөн хүчит амьтныг нэгтгэн “ертөнцийн дөрвөн хүчтэн” гэж нэрлэх болсон” (Арьяасүрэн, Нямбуу, 1992: 733) гэх буюу “энэтхэг, хятадад анх үүссэн” (Арьяасүрэн, Нямбуу, 1992: 733) зэргээр тайлбарласан байх нь нийтлэг юм.

Монгол аман зохиол судлалын нэгэн чухал чиглэл нь дүрийн судалгаа бөгөөд бид өмнөх судалгаагаар монгол аман зохиол дахь луу, хангарди, арслангийн дүр, дүрслэл, бэлгэдлийг тодорхой хэмжээнд судлан шинжилсэн тул энэ өгүүлэлд барын дүр, дүрслэл, утга бэлгэдлийг тодруулахыг зорилоо. Сэдвийн судлагдсан байдлын хувьд бидний олж үзсэнээр хээний бэлгэдлийг судлаач Х.Нямбуу, С.Дулам, Ц.Ядамжав нар, зүүдний бэлгэдлийг С.Дулам нар судлан шинжилжээ. Өгүүлэн буй судлаачдын санал дүгнэлтүүд нь өөр бусад судалгаа шинжилгээний явцад товч дүгнэсэн буй учир энэхүү сэдвийг нарийвчлан судлах нь зүйтэй юм.

2. Судалгааны арга зүй

Бид энэ өгүүлэлд тууль, домог, үлгэр, оньсого, зүйр цэцэн үг зэрэг аман зохиолын төрөл зүйлсэд өгүүлж буй барын дүрийг уламжлалт ан ав, зүүд, цагийн бэлгэдэл, газар шинжих ёс зэрэгтэй харьцуулан, задлан шинжилж, тэдгээрийн утга бэлгэдлийг тайлан тайлбарлахыг зорилоо.

3. Монгол аман зохиолд барыг дүрсэлсэн нь

Ойн буюу уулын эзэн гэж үлгэр домогт гардаг бар нь эрэлхэг баатарлагийн бэлгэдэл бөгөөд энэ утгаар монголчууд нэлээд эртнээс урлаг, уран сайхны бүтээлүүдэд дүрсэлж ирсэн байна. Тийм ч учраас түүнийг авлахад хүртэл тусгай тогтсон дүрэм цаазтай ажээ. Тухайлбал, “Барсын авыг ерийн хүн авлаж болохгүй ёстой, хаан ноёд сая барсын авыг авалдаг. Бас барсын авыг авлах жагсаалын сэв зэв, жадач баатар хүчит хүн болохыг найм, арав, арван хоёр буюу нэг, нэг багцадаар зэрэг дарга хэдэн бүлгээр бэлтгэж жадчиныг тогтоодог. Бас барсыг авлах үед хаан аль ноёны нэрээр захиа буулган авлах газрын уулын эзнийг архи сацаж тахиад, барсын ёсгүй явсныг хэлж, эзэдсэн тул авламуй хэмээн хэдэн үг шүлэг хэлж уулын эзнээ ёсгүй барсыг хорьж авын дотор оруулж өгөх авын ёсоор аваачмуй хэмээн даатгаж авалдаг” (Лувсанчойдон, 2010: 148) байна. Монгол угсаатны ан агнуурын соёл нь байгаль, амьтны үр өгөөжийг амьдрал ахуйдаа ашиглах буюу хоол хүнс, хувцас хунар, гэр орондоо

хэрэглэх үндсэн хэрэгцээнээс үүссэн хэдий ч зүйл бүрийн бэлгэдэл, хорио цээр, зан үйлийн цогц болон хөгжсөн байдаг. Амьтан бүрийн онцлогт тохирсон агнуурын олон арга байхаас эхлээд нэрийг эерүүлэн цээрлэх, анд явах цаг, өдрийг шинжих, идээ, сацал өргөх, “Ганзагын сан” зэрэг ан авд олз омогтой явахыг бэлгэдсэн олон зан үйл бий болохын зэрэгцээ арьс үс, тарга тэвээрэг гүйцээгүй ан амьтан, нялх төл, хөхүүл эх амьтан агнах, сүргээр нь устгах зэргийг ихэд цээрлэдэг билээ. Үүний дотроос бар бол онцгой ан мөн тул дээр өгүүлсэнчлэн агнах хүнийг шинжин томилж, уул усанд даатган залбирснаар авладаг ажээ.

Мөн бар зүүдлэх нь “хан ноён язгууртантай, эр хүмүүнтэй, тэдэнд тохиолдох адас зэтгэр, хорлолтой учир холбогдож, түүнийг унан номхруулан зүүдлэх нь тэдгээр адас, зэтгэрийг номхотгон эрхшээлдээ оруулахын бэлгэдэл болдог гэлтэй. Чухам ийм учраас барс ирвэс алав хэмээн зүүдэлбэл тамга олохын, барс бархирав гэвэл муу арилгахын ёр бэлгэ болдог” (Дулам, 2011: 54) агаад “Эрхийдээ эрчтэй Эрийн сайн Хамбуудай мэргэн хаан” туульд:

Манлай цагаан арслан
Малы нь тойрон (тоглож)
Хатан барын зулзага
Хатны нь тойрон (тоглож)
Зүүдлэв гэнэ (Халх ардын тууль, 1991: 158) гэдэг.

Монгол аман зохиолын төрөл зүйлсээс барыг ерөнхийд нь ажиглахад мөн л энэхүү утгаар буюу “Уулан дээр бар тоглоход, Уяан дээр илжиг үргэнэ” гэх мэтчилэн дүрсэлсэн байх нь энэхүү амьтны бяр чадал, зориг самбааг цөөн үгэнд багтаан илэрхийлсэн байна. Тухайлбал, “Арван хоёр жилийн магтаал”-д:

“Арын модонд нутагтай
Арван зургаан араатай
Амьтан бүхнийг айлгадаг
Алаг эрээн бар юм даа” (Батболд, 1993: 136) эсвэл

Агуул модонд нутагтай
Арван бухын идтэй
Амьтан бүхнийг айлгадаг
Агуур ихтэй барс жил (МАЗТДБ, 2011: 166)

гэх буюу “Онъого”-д бол:

“Аглаг уулнаа оршсон учраас
Агуу хүчин асар төгөлдөр боловч
Ахмадаа ёсолж хүндлэхийг үл мэднэ
Ажиглан үзвэл өвдөг нь далд”
“Уул хаданд орших оронтой
Араатан олондоо Ван нэртэй”
“Хүр хүр дуутай
Хүрэн эрээн биетэй

Гал шар нүдтэй

Галзуу хурц зантай” (Түмэн онъого, 1966: 86) гэж түүний амьдрах орон, өнгө зүсийг илэрхийлэхийн дээр хурц ширүүн зан авир, хүч чадлыг нь онцгойлон тодотгодог байна.

а. Монгол үлгэр, домог дахь барын дүр

Монгол домог үлгэрт “Муур эрт цагт, гаргасан үрээ голж нэг сайхан хүч чадалтай хүү төрүүлэх юм сан гэж боддог байжээ. Тэгсээр байж мануулыг гаргаж гэнэ. Энэ надаас дээрдэх юмгүй давжаа биетэй юм гэж голжээ. Тэгээд шилүүсийг гаргаж, сүүл богинотой, жавхлан муутай юм гэж бас голжээ. Дараа нь ирвэсийг гаргаж, хүч чадал гайгүй боловч эрээн цоохор биетэй, дэндүү урт сүүлтэй гээд бас голжээ. Тэгтэл барсыг төрүүлж түлэгдсэн юм шиг арлан тарлан цоохор, авир догшин ууртай юм гэж мөн санаанд нь хүрсэнгүй дахиад нэг хүү төрүүлтэл магнай дээрээ цог шиг улаан нүдтэй хар хул гэдэг амьтан гарч иржээ” (МАДҮ, 1989: 136) хэмээн өгүүлдэг. Энэхүү домогт муурын (мийнхэн) овгийн амьтад буюу мануул, шилүүс, ирвэс, барсыг нэгэн овгийн амьтад болохыг онцлоод монгол үлгэр, домогт өгүүлдэг магнайдаа цог шиг улаан нүдтэй, догшин ширүүн авиртай Хар хул хэмээх амьтныг тэдгээрийн нэг хэмээжээ. Мөн “Бар хулын долоон хүү” хэмээх домог үлгэрт бол “Эрт урьд цагт Бар хул гэж магнай дундаа цог шиг хурц нүдтэй аварга амьтан байж гэнэ. Тэрний удам Бар хулын долоон хүү гэж нэрлэдэг. Тэр нь

1. Бар
2. Ирвэс
3. Муур
4. Шилүүс
5. Мануул
6. Шар шувуу
7. Ууль энэ долоон амьтан гэнэ (МАДҮ, 1989: 104) гэдэг. Эл домогт өмнөх

домогт өгүүлсэн муур болон түүний төрүүлсэн дөрвөн амьтан дээр шар шувуу, ууль хоёр шувууг нэмж, “Бар хул” хэмээх амьтан эдгээрийг төрүүлсэн гэжээ. Нийтлэг зүйл нь аль ч домогт эдгээрийг нэгэн удам овгийн амьтад болохыг онцлоод, Бар хул (хар хул) бол тэдгээрээс хамгийн хүчит амьтан гэжээ. Эдгээрээс үзэхэд монгол домогт барс бол муурын овгийн эдгээр амьтдын нэг бөгөөд хүч чадлаар дээгүүр эрэмбэтэй болох нь харагдаж байна. Харин “Муур, барс хоёр” үлгэрт:

“Муур барс хоёулаа аглаг уулын гүн шугуйд айл аймаг болон суухдаа барс нь муурын маажих, үсрэх, мяраахыг нь их л бахархан Ямар сайхан эрдэм бэ?” хэмээн сайшааж, “Эрдэм чадлаа эрх биш дүүдээ зааж өгөх болов уу?” хэмээн бэлэг сэлт барьж муурыг багшаар урьж барсыг зөөлөн зан гарган урнаар аашилсанд муур ч сэтгэл уярч айл аймгийнхаа нүүрийг бодож, багшлахыг зөвшөөрч байдаг эрдмээ зааж өгч гэнэ. Нэгэн өдөр барс сурсан эрдмээ үзүүлэхээр багш барьсан муураас эхлэн, байдаг төрөл садныг нь хүртэл бүр цөмөөрөнг

урьж гэнэ. Маажиж, алгадах, мяраах, үсрэх, булгих, гулгаж мөлхөх хүртэл бүх сурсан эрдмээ үзүүлжээ. Араатны ахмад болсон барс, “Эрдэм заасан багшийн мах аливаа эрдэнээс үнэтэй юм. Өнөөдөр цөм морилон саатсан дээрээ үртэй зулзагатай нь барьж дуусга” гэжээ. Дайллагад оролцсон муурууд үүнийг сонсмогц давхин үсэрч модон дээр авиран гарсанд муу санаат барсууд модон доороо оцойн суугаад, “Ээ! Багшийн эрдмийг бас дутуу сурсан байна шүү дээ. Авирах эрдмийг нь сурсан бол” хэмээн гасалцгаав гэнэ” (МАЗТДБ, 2011: 494) гэдэг.

Энэхүү үлгэрт хоёр амьтны “маажих”, “алгадах”, “мяраах”, “үсрэх”, “булгих”, “гулгаж мөлхөх” ижил чадваруудыг муур бард заасан хэмээгээд барыг муу санаатай, догшин хэрцгий дүрээр илэрхийлжээ. Монгол ардын “Бар хүн хоёр”, “Өвгөн бар хоёр” үлгэрүүдэд барын догшин ширүүн авир, бяр чадлыг хүний оюун ухаан, ов мэх, уран нарийн арга хэрхэн давж буйг өгүүлдэг. Эдгээр үлгэрт бар хүнийг өчүүхэн жижиг биетэй, хүч чадал муутай, арьс хөрс ч байхгүй арчаагүй амьтан хэмээн басаж хүч чадлаа үзээд хүний нарийн арга ухаанд ялагдаж байна. Ийнхүү монгол үлгэрт үнэг, чоно, бар, арслан зэрэг араатан амьтдыг ихэвчлэн сөрөг дүрээр гаргадаг нь мал ахуйн соёл сэтгэлгээтэй холбоотой болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг.

Харин монгол газар усны домогт бол Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын нутагт байх “Бар уулын хавьд дээр үед Жавдан баян, Ожил баян хоёр нутаг булаалдаж, Манжийн зарга шүүх газрын ар Монголыг захирах түшмэл хүртэл заргалдаж, нутаг шинжээч залж иржээ. Шинжээч ийн айлджээ. - Бар уул нь сунаж унтсан барын шинжтэй юм. Үнэхээр ойр орчин нь эрэн баранд байдаг олон шинж байна. Бар уснаас айдаг тул Эх голын бүрдэн нуурууд номхруулж байдаг юм байна. Энэ дошгин бар уулыг аргадаж нутагла. Булаацалдаж нутаглавал үгүйрэл нүүрлэнэ. Та хойд буянаа бодож тохитой эвтэй суувал улам баян болно. “Хүлгийн буянтай Ожил та адуу ихтэй учир задгай ус элбэгтэй зүүн талыг нь барьж нутагла” гэхэд нь “санаа муутай манж чи нар буруу нүүж нутагла” хэмээн заалаа гэж агсарчээ. -Жавдан та хонь олонтой учир хужир мараа сайтай баруун талыг нь түшиж нутагла гэхэд муу санаатай манж чи наран жаргах зүгт нутаг заалаа гэж агсрахад нь шинжээч манж нь: -Хай яасан олон малтай, ямар мунхаг толгойтой, засаг шилж заргалдана, зарлиг дагахгүй ихэрхэнэ, өөрийн ноёны үгэнд орохгүй байгаа улсад хүний ноён юу заана. Хойтон жил манай хүн танай хоёр айл хэрхсэнийг сонсов оо гээд явчихжээ. Хоёр баян хамаг малаа Бар ууланд хурааж, хэрэлдсээр зун нь ган, өвөл нь зуд болж, малын яс, арьс, үс цайрсан нутаг болж. Манжийн заргачийн газраас Бар уулын нэрийг ариутган сольж Цахирын нуруу гэж нэрлэн дөрвөн талд нь олон баатар эрсээр нэрийг нь хахиран сонсгож хүндэтгээд, Эхэн усаа 3 жилд нэг удаа тахиж байх захирамж ирж, Бар уулыг Цахир хэмээн нэрийдсэн гэнэ (МГННМДЧ, 2012: 319).

Мөн Архангай аймгийн Жаргалант сумын Хоолт багийн нутагт байх “Бар цохио”-ны домогт “Урьд эртийн цагт харь холын газраас энэ нутаг хошууныхныг мөхөөх атаа хорсол бүхий ачаа тээсэн тэмээн жингийн цувааг

Яргайтын нуруугаар давуулан явуулж, Чулуут голоор гаргаж гэнэ. Хоолт нутгийнхан түүнийг мэдээд өөдөөс нь аймшигт том бар тосгуулан тавьжээ. Бар харсан тэмээнүүд айхдаа ирсэн замаараа эргэн зугтаав. Тэдгээр тэмээний тоогоор харь нутаг руу хандсан толгой бүхий чулуун шон босгож, харин ад хорлол зайлуулсан бар тэр чигтээ Бар цохио болон мөнхөрчээ” (МГННМДЧ, 2012: 319) гэдэг. Нэгдүгээр домогт уламжлалт газар шинжих ёс болоод догшин ширүүн бар шинжтэй уулыг тахиж номхруулах тухай өгүүлэх бол “Бар цохио”-ны домогт ад хорлол, аюул ослыг бараар зайлуулж буй нь мууг даран сөнөөх утга болоод догшин ширүүн авир ааш аль алиныг нь илэрхийлж байгаа хэрэг юм.

б. Монгол тууль дахь барын дүр

Монголчуудын бүтээн туурвисан аман зохиолын төрөл зүйлсийн дотроос гэр, орд өргөөний дүрслэлийг хамгийн арвин бөгөөд уран яруу дүр дүрслэлээр илэрхийлсэн нь тууль билээ. Монгол туульсын гэр өргөөний дүрслэлд барыг дүрслэхдээ:

“Арслан барыг базгалдуулан сийлсэн

Наян хоёр

Навч бандан авдартай” (Бум эрдэнэ, 1985: 19) хэмээх дүрслэл нийтлэг тохиолддог. Мөн “Аргил цагаан өвгөн” туульд:

“Багана талд нь бар арсланг

Базгалдуулан сийлсэн

Далан таван тэрэмтэй байдаг

Далан гурван уньтай байдаг” (1985: 8) гэдэг бол

“Гэрийн ерөөл”-д:

“Бараан дээр нь наалдуулан сийлсэн

Бар арслан хоёр нь

Өлзийтэй болтугай” (ОМАЗД, 1994: 40) хэмээдэг.

Үүнээс ажиглахад монгол гэрийн баганад арслан, барыг хамтаар урладаг харин авдарт арсланг дангаар урладаг нь нэлээд эрт цагийн уламжлал бололтой байна. Аман зохиолд ийн дүрслэлдэг авдрын хээ угалзыг өнөө цагт хэрхэн урлаж буйг ажиглавал ихэвчлэн хос арслан байх бөгөөд нэг авдрын нүүрэнд бие бие рүүгээ харсан хос арслан дүрслэх эс бөгөөс хоймрын хоёр авдарт нэг нэгээр нь хос болгон дүрслэлдэг бол барыг гэрийн багана, хаалга зэрэгт дүрслэхээс бус авдрын хээ чимэгт ашиглах нь ховор байна. Түүнчлэн “Аргил цагаан өвгөн” туульд бол:

“Багана талд нь бар арсланг

Базгалдуулан сийлсэн байдаг.

Далан таван тэрэмтэй байдаг

Далайн гурван уньтай байдаг

Далай цагаан өргөөг” (1985: 8) гэх буюу

“Баруун талд

Бар арслан хоёрыг

Базгалдуулан сийлээд хийсэн
Ханцуйтай хүний бугуйн дүнтэй
Хар мяндсан хөвчтэйхэн
Есөн их хүчтэйхэн
Ендэрмээн шар цоохор нумыг (л)” (1985: 8)

хэмээн орд өргөөний багана, баатар эрийн нум зэрэгт бар, арсланг хамтатган сийлснийг өгүүлж байна. Мөн өнөө цагт монгол гэрт дөрвөн хүчтэнийг хамтаар дүрслэх, эс бөгөөс хангарди, луу, асрланг дангаар нь урлахаас бус барыг ганцаарчлан дүрслэх нь ховор байна. Харин монгол гэрийн “баганын модыг сонгохдоо бүхээг цагаан өргөөг бататгаж байна хэмээн таван барс нийлсэн (ээж нь барс жилтэй, барс жилийн, барс сарын, барс өдрийн, барс цагт төрсөн) хүнээр баганын мод хөндүүлж авдаг заншилтай байжээ (Гантогтох, 1985: 8). Дөрвөн хүчтэний дотроос луу, бар хоёр арван жилд ордог бөгөөд эдгээр жил, сар, өдрийг ихэд чухалчилж байдаг. Монгол гэрийн баганын мод сонгоход бат бэх, хүч чадлын бэлгэдэл болгож таван барс нийлсэн хүнээр сонгуулдаг бол сүм хийдийн ганжирын модыг “таван луу тохиолдуулах” бэлгэ тааруулж сонгодог ажээ. Тухайлбал “Газрын шинжийн монгол судар”-т өгүүлснээр “Монгол орны зун цагт аянга цахилгаантай аадар бороо элбэг тул сүм хийдийн ганжирыг ихээхэн чухалчилж сонгоно. Ингэхдээ “таван луу тохиолдуулах” бэлгэ сонсож “Луу жилийн, луу сарын, луу өдөр, луу цагт, луу жил”-тэй хүнээр уулын ар гээгнээс тэгш шулуун мод авдаг. Энэ модоор хийсэн ганжир аянга цахилгаанд өртдөггүй” (Газрын шинжийн монгол судар, 2015: 8) гэдэг. Дөрвөн хүчтэний дотроос луу, бар хоёр арван хоёр жилд байдаг бөгөөд эдгээр жил, сар, өдрийг бэлгэшээж “таван луу”, “таван барс” тохиолдуулан аливаа үйлийг хийдэг эртний уламжлалтай ажээ.

Монгол туулийн гэр өргөөний дүрслэлд барыг:

“Баруун барааны эхэнд
Барс тавцан ширээн дээр
Хацарнаас нь гэрэл цацарсан
Хар улаан залуу” (Бум эрдэнэ, 1985: 105) эсвэл
“Багана талд нь бар арсланг
Базгалдуулан сийлсэн
Далан таван тэрэмтэй байдаг
Далан гурван уньтай байдаг” (Аргил цагаан өвгөн, 1985: 8)

гэж “барс тавцан ширээ” хийгээд багананд дүрсэлсэн хэмээсэн байна. Харин “Гэрийн ерөөл”-д бол:

“Бараан дээр нь наалдуулан сийлсэн
Бар арслан хоёр нь
Өлзийтэй болтугай” (ОМАЗД, 1994: 40) хэмээдэг.

Эдгээрээс ажиглахад бар, арсланг хамтаар урладаг байсан байж болох бөгөөд “барс хээ бол аливаа зүйлийг аюул осол, зовлон гамшгаас батлан сэргийлэх утга бэлгэдэл төгс” (Дулам, 2011: 142) хээ ажээ.

Дээрхээс ажиглавал монгол гэрийн мод болоод тавилгад нийтлэг дүрсэлдэг

“ертөнцийн дөрвөн хүчтэн” нь орд өргөөг сахин хамгаалж, муу юм бүхнийг даран дийлэхийн бэлгэдэл утгыг агуулдаг бөгөөд түүнийг эдэлж хэрэглэж буй эзэн хүний бие эрүүл, сэтгэл амгалан, урт нас, удаан жаргалыг ерөөсөн утгатай ажээ.

Харин монгол газар шинжих ёсонд Бар шинжтэй газар орныг ихэд бэлгэшээн аюул осол, гай барцдаас ангид сайн газар гэж үздэг. Тухайлбал “Газрын шинжийн монгол судар”-т: зохист сайн газрын шинж нь “хойдох түшээ уул ойрхон өндөр бөгөөд хаан суудалдаа заларсан адил; өмнө нь булаг суваг алагласан, их ууланд бага уулс нь биширэнгүйгээр өргөх адил. Өмнө зүгт өмнөөс нь хандсан, өмнөх уул сунаж намссан, баруун урагш доош уруудсан хийгээд баруун уул огторгуйд дүүлсэн арслан мэт, зүүн уул барс зогдоруо шилгээсэн адил, намирсан цагаан дарцаг адил, цаад уул магнаг торгон өргөө адил, шар тос тэвшинд хайлан мэлтэрч хуйларсан адил газар нь эрхэм дээд газар мөн (2015: 34) гэжээ. Түүнчлэн “найман бардам газар”-ын зургаадугаарт “эм барсын мөшөөл адил” (ГШМС, 2015: 54), “арван найман бардам газар”-ын тавдугаарт “мөшөөсөн царайт бар адил” (ГШМС, 2015: 54), хүүр тавих газрыг шинжихэд “зориг баатрыг хүсвэл барын мөшөөлд тавь” (ГШМС, 2015: 57), бусдад үл дийлдэх арван газрын зургаадугаарт “барын мөшөөл дийлдэшгүй тул дээдсийг хүсвэл түүнд тавь” (ГШМС, 2015: 66) гэхчилэн барс шинжтэй газрыг аливаа үйлд сайн газар хэмээн үздэг нь харагдаж байна.

Тэрчлэн “Газрын дөрвөн сахиус”-д “Зүүнтээх цагаан хад ба цагаан зам нь барс болно” (ГШМС, 2015: 30), “баруун уул огторгуйд дүүлсэн арслан мэт, зүүн уул барс зогдоруо шилгээсэн адил” (ГШМС, 2015: 34) гэх буюу “Ерийн өлзийт сайн уулын шинж”-д “байшингийн газар үхээрийн газарт зүгийн дөрвөн тэнгэр бүрдвээс сайн. Үүнд зүүн зүгтээ замтай бол цайвар барс мөн” (ГШМС, 2015: 46), “зүүн барс нь цогийн татагч чагтага” (ГШМС, 2015: 46) гэхчлэн зүүн зүгийн хад, уул, зам зэрэг нь барсын шинж бүрдсэн өлзийт сайн газар орон болохыг тэмдэглэжээ.

Өвөрхангай аймгийн нутагт орших Баруун хүрээ буюу Шанхын хийд анх нүүдлийн хүрээ байжээ. Есөн зүйл, Хүрээний бүрд, Асгатын энгэр зэрэг одоогийн Зүйл, Өлзийт сумын нутгаар бууж, нүүж, суурьшин төвхнөх аятайхан зохист газар эрэн явсаар одоогийн бууриндаа суурьшсан гэдэг. Одоогийн энэ газарт хүрээний нүүдэл түр буудаллан үдэлж байх зуураа шинжээчээр шинжлүүлсэн байна.

“Шинжээч шинжээд: -Энэ их сайхан газар юм байна. Хойд талд байгаа Өндөр Улаан уул бүргэд шинжтэй юм. Урд талд байгаа Дулаан Хайрхан уул луу шинжтэй юм. Зүүн талд орших Улаан Халзангийн нуруу хойшоо хараад хөлөө жийгээд хэвтэж байгаа барс шинжтэй юм. Баруун талд нь могой шинжтэй Гурван Худгийн нуруу байна. Мөн Харзны гол, Сарын гол хоёр үдэлж буусан газрын зүүн урд нийлж хойшоо Хөгишийн гол нэртэйгээр урссан нь усан чөдрийн шинжтэй юм. Хүрээ хийд суурьшихад маш тохиромжтой нутаг гэж шинжиллээ (МГННМДЧ, 2011: 320) гэжээ.

Ингэж бүх юмны бэлгэ дэмбэрэл зохирон оршсон тул үүнээс хойш баруун хүрээ дахин нүүлгүй суурьшсан гэдэг. Түүнчлэн “Цагаан сүлдний сан”-д:

“Гурван үе хулсны
Ташуур бариад
Цагаан морин дээр
Зүүн мөрөн дээрээ
Цагаан сэнгэ (арслан) дэвхцүүлэн
Баруун мөрөн дээрээ

Их барс үсэргэн” (ЧХШХ, 2017: 17) хэмээн өгүүлсэн байдаг нь “Чингис хааны шүтээн хөрөг”-үүдэд дүрсэлсэнтэй тохирч буйгаас харвал мөрөн дээрх арслан, барс нь Чингис хааны сүр хүч, эрдэм чадлыг илтгэж буй хэрэг юм.

Монголчуудын шүтлэг бишрэл хийгээд дүрслэх урлагийн чухал дурсгал болох “Чингис хааны шүтээн хөрөг”-т Эзэн Чингис хааныг ирээдүйд залран ирэхийг бэлгэдэн Майдар бурханы хөлөг ногоон халзан морьтой бүтээсэн байдаг. Уг хөрөг одоогоор найм олдод буйг судлаач Г.Ням-Очир эмхэтгэн хэвлүүлснийг үзвэл эдгээр хөрөгт Эзэн Чингис хааныг есөн тэнгэр тойрон буйгаар бурханчлан зурахын зэрэгцээ дөрвөн хүчтэнийг мөн багтаажээ. Хөрөгт дүрслэгдсэн дөрвөн хүчтэнийг ажиглавал хангарди, луу-тэнгэрт, арслан-зүүн мөр, барс-баруун мөрөнд оршиж байна.

Дүгнэлт

Дээрхээс дүгнэн үзвэл монгол аман зохиол дахь барын дүр нь нэгдүгээрт, сүр хүчин, эр чадал, хатуу батын илэрхийлэл, хоёрдугаарт, аливаа дайсны омгийг дарж, муу бүхнийг даран дийлэхийн бэлгэдэл, зарим тохиолдолд ааг омогтны дүрийг илэрхийлдэг байна. Өнөө цагт монгол гэрийн тавилга, дүрсэлж буйгаас харвал дөрвөн хүчтэний дотроос үнэлэмж багатайд тооцогдох бөгөөд зарим тохиолдолд монгол эрэгтэй хүнд ээлгүй гэх зэргээх хэлэлцдэг нь ажиглагдаж байна.

Ном зүй

- Аргил цагаан өвгөн.** (1985). Эмхэтгэн боловсруулсан Р.Нарантуяа, Редактор Х.Сампилдэндэв. Улаанбаатар: Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. [Argil tsagaan ovgon. Ulaanbaatar: Ardiin bolovsroliin yaamnii surakh bichig, setgüüliin negdsen redaktsiin gazar. 1985]
- Арьяасүрэн, Ч., Нямбуу, Х.** (1992). *Монгол ёс заншлын их тайлбар толь*. Тэргүүн боть. Улаанбаатар: Сүүлэнхүү. [Ariyasüren, Ch., Nyambu, Kh. *Mongol yos zanshliin ikh tailbar toli*. Tergüün boti. Ulaanbaatar: Suulenkhiü. 1992]
- Батболд, А.** (1993). *Монгол угсаатны бага нэвтэрхий толь*. I Боть. Улаанбаатар: Сүүлэнхүү. [Batbold, A. *Mongol ugsaatiin бага nevtarkhii toli*. I boti. Ulaanbaatar: Suulenkhiü. 1993]

- Бум эрдэнэ.** (1985). Эмхэтгэгч Б.Катуу, Редактор Д.Цэрэнсодном. Улаанбаатар: Ардын боловсролын яамны сурах бичиг, сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар. [Bum erdene. Ulaanbaatar: Ardiin bolovsroliin yaamnii surakh bichig, setgüüliin negdsen redaktsiin gazar. 1985]
- ГШМС.** (2015). *Газрын шинжийн монгол судар-I*. Монгол, англи хэлнээ орчуулсан Б.Няммыгмар. Улаанбаатар: Содпресс. [Gazriin shijiiin mongol sudar-I. [Mongolian geomancy sutra-I. Mongolian Tibetology Series IV] Ulaanbaatar: Sodpress. 2015]
- ДАЗЧ.** (2017). *Дөрвөд аман зохиолын чуулган*. Эмхэтгэсэн Б.Катуу. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Dorvod aman zokhioliin chuulgan. Ulaanbaatar: Soyombo printing. 2017]
- Дулам, С.** (2011). *Дүрсийн бэлгэдэл зүй, дохио зангааны бэлгэдэл зүй. Монгол бэлгэдэл зүй III*. Монгол соёлын чуулган Х. Редактор Д.Бум-Очир. Улаанбаатар:
- Дулам, С.** (2011). *Зүүд зөн совингийн бэлгэдэл зүй Цагийн бэлгэдэл зүй. Монгол бэлгэдэл зүй IV*. Монгол соёлын чуулган XI. Редактор Д.Бум-Очир. Улаанбаатар: Битпресс. [Dulam, S. *Züüd zon sovingiin belgedel züi Tsagiin belgedel züi*. Ulaanbaatar: Bitpress. 2011]
- Лувсанчойдон.** (2010). *Монгол зан аалийн ойлбор*. Монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлж, тайлбар хийсэн А.Амарсанаа. Улаанбаатар: Монгол уламжлал академи. Бемби сан. [Luvsanchoidon. Mongol зан ailiin oilbor. Ulaanbaatar: Bembi san. 2010]
- МАЗТДБ.** (2011). *Монгол аман зохиолын тайлбарт дээж бичиг*. Эмхэтгэсэн Д.Цэрэнсодном. Улаанбаатар: Тод бичиг. [Mongol aman sokhioliin tailbart deej bichig. Ulaanbaatar: Tod bichig. 2011]
- МГННМДЧ.** 2012. *Монгол газар нутгийн нэрийн мянган домгийн чуулган*. Эмхэтгэсэн Э.Равдан, Т.Түмэндэмбэрэл. Улаанбаатар: Удам соёл. [Mongol gazar nutgiin neriin myangan domgiin chuulgan. Ulaanbaatar: Udam soyol. 2012]
- Монгол ардын үлгэр.** (1982). Эмхэтгэсэн Д.Цэрэнсодном, редактор А.Лувсандэндэв. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Mongol ardiin ülger. Ulaanbaatar: Ulsiin khevleliin gazar. 1982]
- Монгол ертөнцийн гурав.** (2016). Нэмэн засварласан хоёрдахь хэвлэл. Дэлгэрэнгүй удиртгал өгүүлэл бичиж эмхэтгэн боловсруулж, тайлбар зүүлт хийсэн Э.Пүрэвжав, С.Энхжаргал. Улаанбаатар: Соёмбо принтинг. [Mongol yortontsiin gurav. Ulaanbaatar: Soyombo printing. 2016]
- Нандинбилиг, Г., Дулам, С.** (2020). *Монгол аман зохиолын онол II*. Хүүрнэн өгүүлэх аман зохиол, жүжиг наадмын аман зохиол. Монгол соёлын чуулган V. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх. [Nandinbilig, G., Dulam, S. *Mongol aman zokhioliin onol II*. Khüürnen ogüülekhe aman zokhiol, jüjig naadmiin aman zokhiol. Mongol soyoliin chuulgan V. Ulaanbaatar: MUIS-iin khevlekh. 2020]

- ОМАЗД.** (1994). *Ойрад монголын аман зохиолын дээжис*. Ойрад хэл, аялгуу тод бичгээс хөрвүүлэн эмхэтгэн тайлбар бичсэн Д.Баттогтох. Улаанбаатар: [Oirad mongoliin aman zokhioliin deejis. Ulaanbaatar: 1994]
- Өлзийхутаг, Ц.** (1961). *Ертөнцийн гурав*. Редактор Э.Вандуй. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн хэвлэх. [Olziikhutag, Ts. Yortontsiin gurav. Ulaanbaatar: Shinjlekh Ukhaanii khevlekh. 1961]
- Халх ардын тууль.** (1991). *Эмхэтгэсэн Р.Нарантуяа*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Khalkh ardiin tuuli. Emkhetgesen R.Narantuya. Ulaanbaatar: Ulsiin khevleliin gazar. 1991]
- ЧХШХ.** (2017). *Чингис хааны шүтээн хөрөг*. Эмхэтгэж, тайлбар бичсэн Г.Ням-Очир. Улаанбаатар: Мөнхийн үсэг. [Chingis khaani shuteen khorog. Emkhetgej, tailbar bichsen G.Nyam-Ochir. Ulaanbaatar: Munkhiin useg. 2017]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.